




# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



## ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2020

2021 ОН

Танилцуулгыг хянан тохиосон:

Х.Өлзийсүрэн                      Статистикийн хэлтсийн дарга

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Б.Цэрэндорж                      Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Амарзаяа                        Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Энхцэцэг                        Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймаг, Сайншанд хот

Гуравдугаар баг,        гудамж-00

АЗДТГ-ын байр

Утас: 70522749

Цахим шуудан: dornogovi.nso.mn

И-мэйл хаяг: dornogovi@nso.mn

## ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ2.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, дэд салбараар, тэрбум төгрөгөөр, 2016-2020 оноор

ХҮСНЭГТ2.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

ХҮСНЭГТ2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

ХҮСНЭГТ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО, 2020 онд

ХҮСНЭГТ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2016-2020 оноор

ХҮСНЭГТ2.6 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, тэрбум.төг

ХҮСНЭГТ3.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

ХҮСНЭГТ3.2 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

ХҮСНЭГТ4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2017-2020 оноор

ХҮСНЭГТ4.2 ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ аймаг, бүсээр сая төгрөг 2017-2020 он

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар, 2020 онд

ЗУРАГ2.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбар, хувиар, 2019-2020 онд

ЗУРАГ2.3 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр, 2016-2020 он

ЗУРАГ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбар, хувиар, 2016-2020 оноор

ЗУРАГ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар, 2020 онд

ЗУРАГ2.6 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумаар, сая төгрөгөөр, 2020 онд

ЗУРАГ2.7 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр, 2016-2020 он

ЗУРАГ2.8 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар

ЗУРАГ3.1 БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст

ЗУРАГ3.2 БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр

ЗУРАГ3.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг

ЗУРАГ3.4 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо

ЗУРАГ4.1 ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр, 2020 онд

ЗУРАГ4.2 ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2017-2020 оноор

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГТ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

### ОРШИЛ

Монгол Улсын болон бүс нутгийн бусад улс орнуудын эдийн засаг нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаатай холбоотойгоор мал аж ахуй, уул уурхай, барилгын болон худалдааны салбарт ихээхэн өөрчлөлтүүд бий болж,

Манай аймаг нь аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд одоогийн байдлаар хайлуур жонш, цеолет, гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс, никель, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон байна. Мөн тус аймагт Монгол орны хэмжээнд тогтоогдсон хайлуур жоншны нийт нөөцийн 30.0 хувь бий.

Байгалийн баялаг, ашигт малтмал, эрдсийн энэхүү ихээхэн нөөц нь уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих тааламжтай нөхцөл болж байна. Тус аймгийн нутагт орон нутгийн төдийгүй, улс орны эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий Зүүнбаян, Цагаан элсний газрын тос агуулсан хотгор байрладаг. Даланжаргалан сумын Хөх цав болон Өргөн сумын Сэнжит худгийн ордуудыг түшиглэн жилд 1 сая тн-н хүчин чадалтай цементүүдийн үйлдвэрүүд ашиглалтад ороод байна.

Эдгээр үйлдвэрүүдэд эрчим хүч, зам харилцаа, усан хангамж, нийгмийн дэд бүтцүүдийг бий болгож хөгжүүлэх явдал тус аймгийн хувьд геологи, уул уурхайн салбарт дэвшүүлэн тавьж байгаа томоохон зорилтууд болно.

Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр, Дорноговь салбар, УБТЗ ХНН-ийн ЭХУХ 2-р анги тус тус хариуцан ажиллаж байна. Айраг, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд сумд болон Зүүнбаян баг нь төвлөрсөн ус, дулаан хангамжийн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд тус сумдын ус, дулаан хангамж, нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааг “Чандмань-Илч”ХХК, “Чандмань Бадрал” ХХК, “Сизу” ХХК, УБТЗ ХНН-ийн ЭХУХ 2-р анги, БАҮ-ний 3-р ангиуд тус тус хариуцан ажиллаж байна.

Дорноговь аймгийн авто замын сүлжээний нийт урт 3000 гаруй км авто замтай бөгөөд үүнээс Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай 434,1 км хатуу хучилттай авто зам эзэлдэг.

Тус аймагт Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж, одоогийн байдлаар, 50 км суурь далан шорооны ажил хийгдэж 1.9 километр төмөр зам баригдаад байна.

Мөн Алтанширээ сумын нутаг дэвсгэрийн 150 га талбайд газрын тос боловсруулах үйлдвэр баригдаж эхэлж байгаа бөгөөд одоогоор Сайншандаас Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбай хүртэлх 110/10 кВ-ын 18,2 км ЦДАШ, дэд станц, 18,8 км төмөр зам, 16,8 км авто зам барих чиглэлийг баталж ашиглалтад оруулсан. Батлан хамгаалах яамны

захиалгаар Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын 549 айлын орон сууцны 1-р ээлжийн 262 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 20%-тай байна.

Сайншанд сумын нутаг дэвсгэр 486 га газарт 55 МВт хүчин чадал бүхий салхин цахилгаан станц, Замын-Үүд суманд 15 МВт хүчин чадал бүхий нарны цахилгаан станцтай. Уг нар, салхины станц нь Дорноговь аймгийн нийт эрчим хүчний хэрэглээний 80% -тай дүйцэхүйц хэмжээний эрчим хүч үйлдвэрлэж 1 сард дунджаар 10сая кВт/цаг эрчим хүчийг үйлдвэрлэн төвийн эрчим хүчний системд нийлүүлж байна.

Манай аймагт сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний газрууд олноор бий болж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 26.5 хувийг бүрдүүлж эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Түүнчлэн, худалдааны салбар нь хөдөлмөрийн зах зээлд онцгой үүрэг гүйцэтгэдэг салбаруудын нэг юм.

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Бөөний худалдаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эсвэл дараагийн шатны худалдаанд зориулан бөөнөөр борлуулах үйл ажиллагааг хамруулдаг бол харин жижиглэн худалдаанд хүн амын хэрэгцээнд зориулсан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийлгүй эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа багтдаг. "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал" 4.0-ын дагуу дотоод худалдааны салбар дараах 3 дэд салбараас бүрддэг. Үүнд:

Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ дэд салбарт шинэ болон хуучин автомашин мотоциклийн бөөний болон жижиглэнгийн худалдаа, техникийн засвар үйлчилгээ, сэлбэг шатахууны жижиглэн худалдаа (код 45),

Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа дэд салбарт жижиглэн худалдаа, үйлдвэр, байгууллагын хэрэгцээнд барааг бөөнөөр нийлүүлдэг байгууллага, экспорт, импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа (код 46),

Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ дэд салбарт хүн ам, гэр ахуйн хэрэгцээнд зориулан дэлгүүр, лангуу, үүргийн болон захиалга, дуудлагаар бараа худалдах үйл ажиллагаа (код 47) зэрэг багтана.

Албан секторын хамрах хүрээ нь бизнес регистрийн санд бүртгэлтэй бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт болно. Албан бус секторын үйл ажиллагаанд албан ёсоор аж ахуйн нэгж, байгууллага гэж бүртгэгдээгүй, патентын зөвшөөрөлтэй хувиараа худалдаа эрхлэгчдийг оруулж байна. Эдгээрт лангуу, чингэлгийн худалдаа, түргэн үйлчилгээний цэгүүд, гутал засвар, авто засварын үйл ажиллагаанууд орж байна

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбар

| Ойлголт   | Тодорхойлолт  |
|---|---|
| Нийт үйлдвэрлэл   | Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ   |
| Завсрын хэрэглээ  | Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.  |
| Нэмэгдэл өртөг  | Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.  |
| Бүтээгдэхүүний борлуулалт                               | Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ. |
| Аж үйлдвэрийн борлуулалт                                | Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.  |
| Үндсэн үнэ  | Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.   |
| Үйлдвэрлэгчийн үнэ                                      | Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ.  |
| Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ              | Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.  |
| Бүтээгдэхүүн  | Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.   |
| Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл) | Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.   |
| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн                            | Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.  |
| Ажиллагч  | Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой  |

|               |  |
|---------------|--|
|               | ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.                 |
| Ажилласан цаг | Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ. |

#### ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарын богино хугацааны (сарын) мэдээгэдийн засгийн бүх төрлийн үйлажиллагааны салбарын ангилал (ISIC-3.1)-т, урт хугацааны (жилийн) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)-ындагуу уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа гэсэн 4 дэд салбарыг хамруулан авч үздэг.

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг.


Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйлажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.

Сарын давтамжтайгаар: "Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ"-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр, бүтээгдэхүүний борлуулалтыг, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог.

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР


Дорноговь аймагт 2020 оны байдлаар 1854 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 1157 буюу 62.4 хувь нь үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 78 буюу 6.7 хувь нь аж үйлдвэрийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

ЗУРАГ2.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар, 2020 онд



Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт ААНБ-ын 52 буюу 66.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 16 нь буюу 20.5 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 8 буюу 10.3 хувь нь бохир ус, хог хаягдлын менежментийн болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт, 2 буюу 2.6 хувь нь цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэл, усан салбарт ногдож байна.

ЗУРАГ2.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбар, хувиар, 2019-2020 онд






## Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа

Аж үйлдвэрийн салбарийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоог дэд салбараар авч үзвэл 2020 онд боловсруулах салбар 66.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9.9 пунктээр буурчээ.

Харин уул уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар 20.5 хувь байгаа нь өмнөх оноос 1.8 пунктээр, цахилгаан, хий, эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, хог хаягдлыг менежментийн болон цэвэрлэх үйл ажиллагааны салбар 12.8 хувь байгаа нь 8.1 пунктээр тус тус өссөн байна.

*Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт*

ЗУРАГ 2.3 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр, 2016-2020 он



Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 62.1 тэрбум төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, дэд салбараар, тэрбум төгрөгөөр, 2016-2020 оноор

| Салбар  | 2016       | 2017     | 2018     | 2019     | 2020     |
|---|------------|----------|----------|----------|----------|
|   | сая төгрөг |          |          |          |          |
| Дүн   | 25740.9    | 162252.1 | 230744.1 | 198144.2 | 260223.1 |
| Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар   | 14651.3    | 83263.6  | 129134.1 | 89430.8  | 106274.5 |
| Боловсруулах үйлдвэрлэлийн салбар   | 2169.8     | 72238.9  | 92298.2  | 100251.7 | 99997.0  |
| Цахилгаан, дулаан, эрчим хүч үйлдвэрлэлийн салбар   | 7239.8     | 4772.8   | 6710.6   | 6693.9   | 50056.9  |
| Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар | 1680       | 1976.8   | 2601.2   | 1767.8   | 3894.7   |

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 260.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт үйлдвэрлэлтийн 40.8 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрийн салбар, 38.4 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 19.2 хувийг цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэлийн салбар, 1.5 хувийг усан хангамж,

**Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа**


сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбар, хувиар, 2016-2020 оноор**




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн бүтцийг өмнөх онтой харьцуулахад уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар 4.3 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 12.2 пунктээр тус тус буурсан байна. Харин цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэлийн салбар өмнөх оноос 15.9 пунктээр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 0.6 пунктээр, цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэлийн салбар өмнөх оноос 18.1 пунктээр өссөн байна.

**ЗУРАГ 2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, аж ахуй нэгжийн хэлбэрээр, хувиар, 2020 онд**



Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг аж ахуйн нэгжийн хэлбэрээр авч үзэхэд 2020 онд 94.9 хувийг компани, 4.7 хувийг улсын үйлдвэрийн газар, 0.4 хувийг өрхийн аж ахуйн үйлдвэрлэл эзэлж байна.

ЗУРАГ 2.6 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумаар, сая төгрөгөөр, 2020 онд



Аж үйлдвэрлэлийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сумаар авч үзвэл 105270.2 сая төгрөг буюу 45.2 хувийг Даланжаргалан сум, 66773.1 сая төгрөг буюу 25.7 хувийг Хөвсгөл сум, 55208.5 сая төгрөг буюу 23.7 хувийг Сайншанд сум, 12799.5 сая төгрөг буюу 5.5 хувийг Өргөн сум, 12554.7 сая төгрөг буюу 5.4 хувийг Иххэт сум, 5229.3 сая төгрөг буюу 2.2 хувийг Замын-Үүд сум, үлдсэн 93.2 сая төгрөг буюу 0.04 хувийг бусад сумд үйлдвэрлэсэн байна. Даланжаргалан, Өргөн, Иххэт, Сайншанд, Хөвсгөл сумдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өндөр хувийг эзэлж байгаа нь тус сумдад уул, уурхай олборлолт болон боловсруулах салбарын үйлдвэрийн газрууд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой юм.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 160651.6 мян.кв.ц-аар, дулаан 12.3 мян.ккал-аар, ус түгээлт 29.4 мян.м3-аар, сувагжуулалт 31.3 мян.м3-аар, нүүрс 243.9 тонноор, хиам 1.5 тонноор, ааруул 0.2 тонноор, аарц 5.0 тонноор, шар тос 0.6 тонноор, талх 113.6 тонноор, бялуу 1.8 тонноор, хэрчсэн гурил 40.6 тонноор, загсгал цай 477.6 кг-аар, вакуум цонх 604.8 м2-аар, хайрга 23.4 мян.м3-аар, цемент 98.2 мян.тонноор, блок 0.8 мян.ш-ээр, гөлтгөнө 14212.4 тонноор, жижиг төмөр эдлэл 74576.8 мянган төгрөгөөр, модон эдлэл 116520.3 мянган төгрөгөөр, жижиг төмөр эдлэл 5680.0 мянган төгрөгөөр, шохой 19352 тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

*Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа*


ХҮСНЭГТ.2.2 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

| Дэд салбар  | Хэмжих нэгж | 2017    | 2018    | 2019    | 2020     | 2020<br>2019     |
|---|-------------|---------|---------|---------|----------|------------------|
| Цахилган, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж |             |         |         |         |          |                  |
| Цахилгаан эрчим хүч                                 | мян.кв.ц    | 123.3   | 0       | 0       | 160651.5 | 0.0              |
| Дулааны эрчим хүч                                   | мян.ккал    | 111.6   | 120.7   | 188.7   | 201.0    | 106.5            |
| Түгээсэн цэвэр ус                                   | мян.м3      | 784.6   | 886.6   | 985.3   | 1014.7   | 103.0            |
| Сувагжуулалт  | мян.м3      | 577.5   | 668.7   | 744.4   | 775.7    | 104.2            |
| Уул, уурхай олборлох аж үйлдвэр                     |             |         |         |         |          |                  |
| Нүүрс   | тн          | 1455.9  | 1624.8  | 1000.7  | 1244.6   | 124.4            |
| Боловсруулах аж үйлдвэр                             |             |         |         |         |          |                  |
| Адууны мах  | тн          | 10968.7 | 45      | 0.0     | 0.0      | 0.0              |
| Хиам  | тн          | 8.9     | 9.6     | 20.9    | 22.4     | 107.2            |
| Шингэн сүү  | мян.л       | 44.1    | 52.4    | 50.0    | 42.9     | 85.8             |
| Тараг   | мян.л       | 26.4    | 30.1    | 31.1    | 23.4     | 75.2             |
| Аруул   | тн          | 3.7     | 2.4     | 2.0     | 2.2      | 110.0            |
| Цэцгий  | тн          | 2.4     | 3.0     | 2.6     | 2.6      | 100.0            |
| Аарц  | тн          | 4.5     | 3.6     | 3.9     | 8.9      | 228.2            |
| Шар тос   | тн          | 1       | 0.8     | 0.1     | 0.7      | 700.0            |
| Талх  | тн          | 142.4   | 125.8   | 144.1   | 257.7    | 178.8            |
| Нарийн боов   | тн          | 56.8    | 81.8    | 144.2   | 99.1     | 68.7             |
| Бялуу   | тн          | 3.3     | 4.5     | 3.2     | 5.0      | 156.3            |
| Хэвийн боов   | тн          | 1.0     | 1.4     | 0.8     | 0.4      | 48.2             |
| Хэрчсэн гурил                                       | тн          | 32.3    | 17.9    | 26.3    | 66.9     | 254.4            |
| Ногоон цай /Загсгал цай/                            | кг          | 245     | 392.5   | 760.0   | 1237.6   | 162.8            |
| Цэвэр ус  | мян.л       | 2328.9  | 2017.2  | 2355.6  | 2073.8   | 88.0             |
| Вакуум цонх   | м2          | 1875.6  | 2196.8  | 2895.1  | 3499.9   | 120.9            |
| Хайрга  | мян.м3      | 8.7     | 23.9    | 41.8    | 65.2     | 156.0            |
| Бетон зуурмаг                                       | м3          | 3951.5  | 10969.9 | 22423.9 | 16254.9  | 72.5             |
| Цемент  | мян.тн      | 285.7   | 603.9   | 684.3   | 782.5    | 114.4            |
| Блок  | мян.ш       | 23.9    | 7.1     | 4.5     | 5.3      | 117.8            |
| Гөлтгөнө  | тн          |         | 7249    | 16166   | 30378.4  | 187.9            |
| Замын хавтан, хашлага                               | м2          | 1425.0  | 3146.4  | 24041.1 | 20593    | 85.7             |
| Дээл  | ш           | 221     | 374     | 483     | 234      | 48.4             |
| Бусад жижиг оёдол                                   | мян.төг     | 17860.2 | 44477   | 27929.5 | 102506.3 | 3.6 <sup>2</sup> |
| Модон эдлэл   | мян.төг     | 51954.6 | 95122   | 36289.0 | 152809.3 | 4.2 <sup>2</sup> |
| Эсгий, эсгий эдлэл                                  | мян.төг     | 3590    | 2600    | 0       | 0        | 0.0              |
| Шохой   | тн          |         |         |         | 19352    |                  |
| Жижиг төмөр эдлэл                                   | мян.төг     | 822.0   | 560.0   | 5690.0  | 11370.0  | 199.8            |

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2020 онд 357.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ЗУРАГ 2.7 НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр, 2016-2020 он



Нийт бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оноос 56.0 тэрбум төгрөгөөр буюу 18.5 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 2.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

| Салбар   | 2018     | 2019     | 2020     | 2020<br>2019     |
|--|----------|----------|----------|------------------|
|  |          |          |          | хувь             |
| Дүн  | 339177.4 | 301910.3 | 357885.7 | 118.5            |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр   | 230927.3 | 192829.6 | 164699.4 | 85.4             |
| Нүүрс олборлолт  | 230338.7 | 191876.8 | 159179.5 | 83.0             |
| Бусад ашигт малтмал олборлолт  | 588.6    | 952.8    | 5519.9   | 5.7 <sup>2</sup> |
| Боловсруулах аж үйлдвэр  | 98852.2  | 99236.1  | 137102.6 | 138.2            |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл  | 2501.0   | 1748.5   | 3327.9   | 190.3            |
| Хувцас үйлдвэрлэл  | 105.4    | 165.7    | 151.9    | 91.7             |
| Гутал үйлдвэрлэл   | 21.4     | 38.6     | 44.9     | 116.3            |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл  | 122.1    | 99.6     | 171.2    | 171.9            |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад жижиг төмөр эдлэл үйлдвэрлэл  | 0.6      | 17.3     | 11.9     | 68.8             |
| Боловсруулах үйлдвэрийн бусад  | 96101.7  | 97166.4  | 133394.8 | 137.3            |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдлыг болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа | 9397.9   | 9844.6   | 56083.7  | 5.6 <sup>2</sup> |


Тайлбар: <sup>2</sup> - дахин их

**Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа**

Нийт борлуулалтын 164.7 тэрбум төгрөг буюу 46.0 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар, 137.1 тэрбум төгрөг буюу 38.3 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 56.1 тэрбум төгрөг буюу 15.7 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдлыг болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар эзэлж байна.

Нийт борлуулалтыг дэд салбараар өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулах салбар 37866.5 сая төгрөгөөр буюу 38.2 хувиар, цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдлын болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 46239.1 сая төгрөгөөр буюу 5.6 дахин өссөн байна.

ЗУРАГ 2.8 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, дэд салбараар



Нийт борлуулалтын 38.7 хувийг буюу 133.4 тэрбум төгрөгийг гадаад зах зээлд борлуулсан байна.

**Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа**

ХҮСНЭГТ2.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО, 2020 онд

| Салбар  | ААН | ИРГЭН |
|---|-----|-------|
| Дүн   | 51  | 57    |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр  | 9   |       |
| Нүүрс олборлолт   | 7   |       |
| Бусад ашигт малтмал олборлолт   | 2   |       |
| Боловсруулах аж үйлдвэр   | 36  | 57    |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл   | 16  | 37    |
| мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл  |     |       |
| сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл   | 1   |       |
| хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл   | 15  | 37    |
| Хувцас үйлдвэрлэл   | 3   | 11    |
| Гутал үйлдвэрлэл  |     | 2     |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл   | 3   | 5     |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл   |     | 2     |
| Боловсруулах үйлдвэрийн бусад   | 14  |       |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт  | 3   | 0     |
| Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа | 3   | 0     |

Аж үйлдвэрийн салбарын мэдээнд нийт 108 нэгж хамрагдсанаас 57 нь өрхийн аж ахуй эрхэлсэн иргэд байна. 2020 оны мэдээнд цахилгаан үйлдвэрлэлийн чиглэлээр 1 ААНБ, нүүрс олборлолт 3 ААНБ, гутал үйлдвэрлэлт 1 иргэн, цэвэр ус үйлдвэрлэлт 1 иргэн, хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр 9 иргэн тус тус шинээр хамрагджээ.

ХҮСНЭГТ2.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2016-2020 оноор

| Салбар                               | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2020<br>2019 |
|--------------------------------------|------|------|------|------|------|--------------|
| Бүгд                                 | 1142 | 1436 | 1685 | 2008 | 2375 | 118.3        |
| Уул, уурхай олборлох үйлдвэр         | 269  | 144  | 480  | 551  | 573  | 104.0        |
| Боловсруулах үйлдвэр                 | 474  | 948  | 822  | 1080 | 1202 | 111.3        |
| Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж | 399  | 344  | 383  | 377  | 600  | 159.2        |

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 18.9 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл уул уурхай, олборлох салбарын ажиллагчдын тоо 4.0 хувиар, боловсруулах салбарын ажиллагчдын

**Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын судалгаа**

тоо 11.3 хувиар, цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын ажиллагчдын тоо 59.2 хувиар тус тус өсчээ.

ХҮСНЭГТ2.6 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, тэрбум.төг

| Салбар  | 2016          | 2017  | 2018  | 2019  | 2020  |
|---|---------------|-------|-------|-------|-------|
|   | тэрбум.төгрөг |       |       |       |       |
| Дүн   | 29.8          | 107.4 | 126.2 | 98.7  | 114.7 |
| Уул уурхай олборлох аж үйлдвэр  | 54.5          | 645.4 | 222.6 | 165.0 | 157.7 |
| Нүүрс олборлолт   | 54.5          | 645.4 | 222.6 | 193.1 | 161.2 |
| Бусад ашигт малтмал олборлолт   |               |       |       |       | 137.6 |
| Боловсруулах аж үйлдвэр   | 23.3          | 113.7 | 106.6 | 92.1  | 92.4  |
| Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл   | 11.6          | 209.2 | 7.6   | 11.1  | 13.6  |
| Хувцас үйлдвэрлэл   | 3.0           | 4.8   | 3.4   | 10.1  | 5.1   |
| Гутал үйлдвэрлэл  | 5.4           | 4.7   | 13.4  | 11.4  | 2.1   |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл   | 3.6           | 5.8   | 15.9  | 13.8  | 18.3  |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад жижиг төмөр эдлэл үйлдвэрлэл   | 0.7           | 0.4   | 0.4   | 1.4   | 8.7   |
| Боловсруулах үйлдвэрийн бусад   | 32.1          | 86    | 133.5 | 104.6 | 104.4 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт  | 33.4          | 29.8  | 32.0  | 34.1  | 333.7 |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл   | 33.4          | 29.8  | 32.0  | 34.1  | 333.7 |
| Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа | 8.9           | 29.8  | 32.0  | 34.1  | 10.8  |
| Ус ариутгал, усан хангамж, хог хаягдал зайлуулах  | 8.9           | 29.8  | 32.0  | 34.1  | 10.8  |

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж өмнөх оноос 16.2 хувиар өссөн байна.




ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

Бизнес регистрийн санд 2020 оны эцэст нийт 1854 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 71 буюу 3.8 хувь нь барилгын салбарт хамаарч байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь өмнөх оноос 0.6 пунктээр нэмэгдсэн байна.


Барилгын салбарт бүртгэлтэй 71 ААНБ-аас 49 буюу 69.0 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 9 ААНБ буюу 15.5 хувиар буурсан байна.

ЗУРАГ3.1 БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст



Аймгийн ДНБ-ий хэмжээ 2019 оны гүйцэтгэлээр 460.6 тэрбум төгрөгт хүрсний 6.9 тэрбум төгрөг буюу 1.5 хувийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 6.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2019 онд 1.5 хувь байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ3.2 БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, сая төгрөгөөр



2020 онд нийт 538.9 тэрбум төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.1 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 29.4 хувийг улсын төсвийн, 0.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

ХҮСНЭГТ3.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

|                        | 2016    | 2017    | 2018    | 2019    | 2020    |
|------------------------|---------|---------|---------|---------|---------|
| Улсын дүн              | 2482407 | 3130661 | 4009818 | 4747504 | 4695932 |
| Төвийн бүс             | 176338  | 662848  | 1417255 | 1738541 | 1999880 |
| Дорноговь аймаг        | 17046.2 | 111924  | 423235  | 170117  | 538909  |
| Улсын дүнд эзлэх хувь  | 0.7     | 3.6     | 10.6    | 3.6     | 11.5    |
| Бүсийн дүнд эзлэх хувь | 9.7     | 16.9    | 29.9    | 9.8     | 26.9    |

Барилга угсралт их засварын ажлын 89.0 хувь нь инженерийн барилга, байгууламж, 6.7 хувь нь орон сууцны бус барилга, 3.2 хувь нь орон сууцны барилга, 1.1 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оноос орон сууцны бус барилгынх 20.1 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 7.5 пункт, их засварын ажлынх 2.5 пунктээр тус тус буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 30.2 пунктээр нэмэгдсэн.

ЗУРАГ3.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг



ХҮСНЭГТ3.2 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

|               |        | Хэмжих нэгж | 2017    | 2018    | 2019    | 2020   | 2020 / 2019 |
|---------------|--------|-------------|---------|---------|---------|--------|-------------|
| Нийт талбай   |        | м2          | 18696.5 | 19666.6 | 31143.6 | 3941.1 | 12.7        |
| үүнээс        | Төрийн | м2          | 126.0   |         | 192.0   |        |             |
|               | Хувийн | м2          | 18570.5 | 19666.6 | 30951.6 | 3941.1 | 12.7        |
| Сууцны талбай |        | м2          | 14792.5 | 15790.4 | 26098.6 | 3669.3 | 14.1        |
| үүнээс        | Төрийн | м2          | 116.0   |         | 160.0   |        |             |
|               | Хувийн | м2          | 14676.5 | 15790.4 | 25938.6 | 3669.3 | 14.1        |

ЗУРАГ3.4 АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ, өрх, хүн амын тоо



ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГТ ХУДАЛДААНЫ  
САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Худалдааны салбарын эдийн засгийн өсөлт


Бизнес регистрийн санд 2020 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй нийт 1157 аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 307 аж ахуйн нэгж буюу 26.5 хувь нь худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага байна.

ХҮСНЭГТ4.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2017-2020 оноор

|   | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|------|------|------|------|
| ААНБ-ын тоо-Бүгд                                | 1140 | 1599 | 1757 | 1854 |
| Үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллагын тоо   | 1070 | 1163 | 1265 | 1157 |
| Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо        | 296  | 314  | 373  | 307  |
| Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь | 27.7 | 27.0 | 29.5 | 26.5 |

Аймгийн хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2020 онд 307 болж өмнөх оноос 66 буюу 17.7 хувиар буурч, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын дүнд эзлэх хувиар авч үзвэл 2020 онд 26.5 хувь болж, 2017 оноос 1.2 пунктээр буурсан байна. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байсан бол 2020 онд 307 болж буурсан байна.


ЗУРАГ4.1 ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ажиллагчдын тооны бүлгээр, 2020 онд



Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын 97.0 хувийг 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага, 10-19

ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 2.7 хувийг, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 0.3 хувийг бүрдүүлж байна.

ЗУРАГ 4.2 ХУДАЛДААНЫ САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, 2017-2020 оноор



Худалдааны салбарт ажиллагчдын тоо 2020 онд 307 болж өмнөх оноос 17.7 хувиар, буурч, 2017 оноос 3.7 хувиар өсчээ. Сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж жилд дунджаар 38 хүнээр нэмэгдэж байсан бол 2020 онд ажилчдын тоо өмнөх оноос 66 буюу 17.7 хувиар буурсан нь цар тахал ковидын улмаас дотоодод хөл хорио тогтоосонтой холбоотойгоор нийт эдийн засаг, болон худалдааны салбарын үйл ажиллагаа бусад салбаруудтай харьцуулахад их хэмжээгээр хязгаарлагдаж, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд хүндрэл учирч байна ашиг орлого доголдох эрсдэл тулгарч аж ахуйн нэгж байгууллага ажилчдын тоог цөөрүүлж цомхотгол хийсэнтэй холбоотой байна.

*Худалдааны нийт борлуулалт аймаг, бүсээр*

Худалдааны салбарын нийт борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрийг хэлнэ.

ХҮСНЭГТ 4.2 ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ аймаг, бүсээр сая төгрөг 2017-2020 он

| Аймаг      | 2017     | 2018     | 2019     | 2020     | 2020<br>2017     | 2020<br>2019 |
|------------|----------|----------|----------|----------|------------------|--------------|
| Дорноговь  | 31030.6  | 52,208.7 | 69158.5  | 62737.9  | 2.0 <sup>2</sup> | 90.7         |
| Дундговь   | 12202.3  | 16998.3  | 21189.2  | 19526.8  | 160.0            | 92.2         |
| Өмнөговь   | 120074.3 | 214232.7 | 168651.1 | 189074.7 | 157.5            | 112.1        |
| Сэлэнгэ    | 24141.1  | 36763.7  | 39363.4  | 42189.7  | 174.8            | 107.2        |
| Төв        | 25719.2  | 32298.3  | 35755.3  | 53321.1  | 2.0 <sup>2</sup> | 149.1        |
| Дархан-Уул | 62939.2  | 87867.6  | 97814.9  | 90497.4  | 143.8            | 92.5         |
| Говьсүмбэр | 18614.3  | 30515.1  | 39117.0  | 17239.3  | 92.6             | 44.1         |

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2020 онд 62737.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 6420.6 сая төгрөг буюу 9.3 хувиар буурсан байна.

## ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтийн хувьд 2020 онд 260.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 62.1 тэрбум төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн байна. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн дийлэнх хувийг уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэл эзэлж байна.

Төр засгаас үйлдвэржилтийг дэмжсэн бодлого хөтөлбөрийн амжилттай хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, цаасан уут, гар нүүрийн саван, амны хаалт/маск/, банш бууз зэрэг бүтээгдэхүүнийг шинээр нэмж үйлдвэрлэжээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2020 онд 357.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 38.7 хувь буюу 133.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний гадаад зах зээлд борлуулсан байна. Нийт борлуулалтын 164.7 тэрбум төгрөг буюу 46.0 хувийг уул, уурхай олборлох үйлдвэрлэлийн салбар, 137.1 тэрбум төгрөг буюу 38.3 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 56.1 тэрбум төгрөг буюу 15.7 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдлыг болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар эзэлж байна.

Барилгын нийт хөрөнгө оруулалтын 29.4 хувийг улсын төсвийн, 0.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Барилга угсралт их засварын ажлын 89.0 хувь нь инженерийн барилга, байгууламж, 6.7 хувь нь орон сууцны бус барилга, 3.2 хувь нь орон сууцны барилга, 1.1 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оноос орон сууцны бус барилгынх 20.1 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 7.5 пункт, их засварын ажлынх 2.5 пунктээр тус тус буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 30.2 пунктээр нэмэгдсэн.

Манай аймгийн хувьд Худалдааны салбар нь ажиллах хүчний зах зээлд томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг бөгөөд сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөлтүүд бий болж худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага тогтмол өсч байсан бол 2020 онд өмнөх оноос 66 аж ахуйн нэгж байгууллагаар буурсан байна. Энэ цар тахал ковидын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдож, үйл ажиллагаа нь зогссон байна.

Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн эзлэх хувь нь 2020 оны байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 26.5 хувийг эзэлж, 2017 оноос 1.2 пунктээр буурсан байна. Худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын 97.0 хувийг 1-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага, 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж,

байгууллага 2.7 хувийг, 50-иас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 0.3 хувийг бүрдүүлж байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 онд 62737.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 6420.6 сая төгрөг буюу 9.3 хувиар буурсан байна. Энэ нь цар тахал ковидын улмаас дотоодод хөл хорио тогтоосонтой холбоотойгоор нийт эдийн засаг, болон худалдааны салбарын үйл ажиллагаа хязгаарлагдаж, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд хүндрэл учирч байна ашиг орлого доголдох эрсдэл тулгарсантай холбоотой байна. Худалдааны салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болох юм.

АШИГЛАСАН НОМ МАТЕРИАЛ:

1. [www.1212.mn](http://www.1212.mn) сайт
2. [dornogovi.nso.mn](http://dornogovi.nso.mn) сайт
3. Аймгийн нийгэм эдийн засгийн 2019 оны жилийн эцсийн танилцуулга